



**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан**

2017 он

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
ОУЗСТ-ийн Ажлын алба

Агуулга

Нэг. Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ	3
1.1. Товч хураангуй	3
1.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр дүн, үр нөлөө, ахиц дэвшил.....	4
1.3. Үндсэн гол үйл ажиллагаанууд-2017 он.....	6
Хоёр. 2017 оны Ажлын төлөвлөгөөгөөр тавьсан зорилгуудаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн	8
2.1. Нэгдүгээр зорилго: ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтын дүнгээр доогуур үнэлгээ авсан үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг ахиулах, Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж, үр дүнд хүрсэн байна	8
2.2. Хоёрдугаар зорилго: Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэл тайланг боловсруулах, батлах хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:.....	9
2.3. Гуравдугаар зорилго: ОУИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:	10
2.4. Дөрөвдүгээр зорилго: Ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох замын зургийн 2017 онд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд: 11	
2.5. Тавдугаар зорилго: Гэрээний ил тод байдлыг хангах хүрээнд дараах ажлуудыг хийв.Үүнд:.....	12
ГУРАВ. ОУИТБС-ЫН ШААРДЛАГА БҮРИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ	14
3.1. 2016 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх	14
Дөрөв. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тоймыг дараах 2 хүснэгтээр харуулав. Үүнд:.....	16
4.1. Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016.....	16
4.2. Өмнөх жилийн тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт ША 7.3 /2015 оны тайлангийн/	17
Тав. Монгол Улсад 2017 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд үүссэн бэрхшээл, хариу арга хэмжээ, авсан сургамж.....	19
Зургаа. Зарцуулалтын тайлан	20
Долоо. Хурал үйл ажиллагаанд оролцсон байдал, туршлага солилцох, хурлуудын ирц	20
Найм. Тайланг боловсруулсан:	24
Ес. Хавсралтууд	24

Нэг. Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ

1.1. Товч хураангуй

Монгол Улс ОУИТБС-ыг 2017 онд тогтвортой, олдсон боломжоо хангалттай түвшинд ашиглан хэрэгжүүлж чадсан гэж үзэх үндэстэй байна. Ил тод байдлын гол бүтээгдэхүүн болох 2016 оны нэгтгэл тайланг хугацаандаа гаргаж, олон нийтийн хүртээл болгосон байна.

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс санаачлан боловсруулсан Засгийн газрын 222 тоот тогтоолын нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж, шинэчлэн батлуулсан байна. Тогтоолоор ОУИТБС-ын стандарт, шаардлага, зөвлөмж, дүрэм, протоколыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авсан байна.

ОУ-ын удирдах хороо 1 дүгээр сард Монгол Улсын “Баталгаажуулалтын” дүнг хэлэлцээд ОУИТБС-ын стандартыг “мэдэгдэхүйц ахицтай” хангасан үнэлгээ өгсөн нь Монгол Улсыг сайн үнэлсний тодорхой жишээ юм.

Энэ онд анх удаа 5 дугаар сард жилийн нэгтгэл тайлангийн эхлэлийн семинарыг зохион байгуулж, Хараат бус хянагч нэгтгэгчийн ажлыг нь эрт эхлүүлсэн байна. Үүний үр дүнд нэгтгэл тайлангаа чанартай сайн гаргахын хамт “Баталгаажуулалтаас өгсөн зөвлөмжүүдийн” ихэнхийг хэрэгжүүлж чадсан байна.

Ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 1227 компани, Засгийн газар 2086 компаниас хүлээн авсан орлогоо ил тод цахимаар тайлагнаж, 2016 оны нэгтгэл тайланг Монгол Улсын тэргүүлэх 213 компаниар гаргасан байна.

Орон нутагт ОУИТБС-ыг сурталчлах, орон нутгийн харилцан ойлголцлыг бүрдүүлэх зорилгоор ЕСБХБ-ын санхүүжилтээр Адам Смит хүрээлэн, Монголын Интерконсалтинг компанитай хамтран Ерөө, Заамар, Гурвантэс, Бор-Өндөр, Дэлгэрэх сумдад туршилтын төсөл хэрэгжүүлж, төсөл дуусах шатандаа явж байна.

Олборлох салбарын аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч эздийг ил тод болгох “Замын Зураг” төлөвлөгөөнөөс 2017 онд төлөвлөсөн ихэнх ажлуудыг хэрэгжүүлж, ЗГХЭГ-д Засгийн газрын тогтоолд заасны дагуу санал оруулаад байна.

Олборлох салбарт байгуулагдсан гэрээнүүдийн ил тод байдлыг хангахын тулд Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр гэрээний цахим санг үүсгэж, олон нийтийн хүртээл болгоод байна.

1.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр дүн, үр нөлөө, ахиц дэвшил

1. Тайлан гаргаж байгаа нь компанийн хариуцлагатай байдал нэмэгдэж буйн бодит жишээ юм.

2006 онд анх 64 компани ОУИТБС-ын тайлан гаргаж байсан бол 2016 онд 1227 компани тайлан гаргажээ. Тайлан гаргаж байсан компанийн тоо 20 дахин өссөн. Тэр хирээр хариуцлагатай компаниудын тоо нэмэгдсэн.

2. Засгийн газраас тайлангаа саадгүй гаргаж байгаа нь хариуцлагатай байдал, манлайлал сайжирч байгаагийн илрэл юм.

2006 онд Засгийн газар 134 компаниас олборлох үйлдвэрлэлийн орлогыг хүлээн авсан тайлангаа гаргаж байсан бол 2016 онд 2086 компаниар тайлангаа гаргажээ. Засгийн газар нь сүүлийн 5 жилд тасралтгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх компаниар бүх орлогоо тайлагнаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Засгийн газрын тайланд хамрагдсан компаниудын тоо 15 дахин өссөн. Тэр хэмжээгээр Засгийн газрын хариуцлагатай байдал өсч байна гэж үзэх үндэстэй байна.

3. Бодитой мэдээллийн хүртээмж эрс нэмэгдэж, ОУИТБС-ын тайлагнал цахимжав.

2006-2013 он хүртэл Компани, Засгийн газар тайлангаа цаасаар гаргадаг байсан бол 2014 оноос эхлэн цахимаар гаргаж, Засгийн газар, Компанийн үнэт цаг, цаас, зардлыг хэмнэсэн “Эко” тайланруу дөхөж очсон байна.

4. Засгийн газар, Компани, Иргэний нийгэм мэдлэг, чадавхтай болов.

3 талын чадавх нэмэгдэж байгаа нь жил бүр тайлан гаргаж, хэлэлцүүлэг зохион байгуулж, тайлангаа олон улсын стандартын жишиг хугацаанаас 1 жилийн өмнө гаргаж 2011 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлангаас хэвшээд байна.

5. Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд өсөв.

2011, 2016 онд ОУИТБС-ын даргын нэрэмжит Болор цомоор шагнуулав. Эдгээр шагналууд нь жил бүр тайлангийн чанарыг сайжруулдаг, хүртээмжийг нэмэгдүүлснийг үнэлсэн явдал байлаа.

6. Монгол Улсын хөрөнгө оруулалтын зэрэглэл өсөв. Чингис хаан, Самурай бонд зэрэг богино хугацаат хөрөнгийг Монгол Улс олон улсын зах зээлээс босгож, улс оны нийгэм эдийн засаг, хөрөнгө оруулалт, хөгжлийн олон асуудлыг шийдвэрлэж байна.

7. Монгол Улсын байгалийн баялгийн засаглалын индекс 64 болж нэмэгдэв.¹

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газар, компани, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бодитойгоор идэвхжин, нэмэгдэж, итгэлцлийг уур амьсгал сайжирснаар засаглалын энэхүү индекс өсөх шалтгаан болов.

8. Төв, орон нутгийн төрийн байгууллагуудад олгосон, өмнө нь ил болдоггүй байсан хандив дэмжлэгийг 2007 оноос хойш ил тод болгож байна.

УИХ, Засгийн газраас замбараагүй хандив дэмжлэгийг асуудлыг холбогдох хуулиудаар зохицуулах арга хэмжээ авч байна. Тухайлбал, 2010 оны Сангийн сайдын 45 дугаар тушаал, 2011 онд батлагдсан “Төсвийн тухай” хуулийн 25 дугаар зүйл, 2012

¹ Өмнөх оноо 2013 онд 51 байсан.

онд батлагдсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17.1, 17.4-заалтуудаар хандив дэмжлэгтэй холбогдсон асуудлыг зохицуулж байгаа нь томоохон ахиц дэвшил болж байна.

9. Байгаль орчны нөхөн сэргээлтийн дүн мэдээ, холбогдох барьцааг ил тод болгож байна.

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээг 2007 оноос хойш жил бүр ил тод болгож байгаа нь ОУИТБС-ын стандартад байдаггүй шаардлагыг Монгол Улс онцгойлон хэрэгжүүлж байгаа нь стандартыг давсан үйл ажиллагаа болж байна.

10. ОУИТБС-ын салбар болох Дэд зөвлөлийг хөдөө орон нутаг, нийслэлд байгуулж, компани, төв орон нутгийн хоорондын харилцаа холбоог сайжруулах боломжтой болов.

Орон нутгийн хамтын ажиллагааны олон бодит жишээг дурдаж болно. 20 аймаг, 1 дүүрэг, 18 суманд ОУИТБС-ын дэд зөвлөл байгуулан ажиллаж байна.

11. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлснээр олон нийтийн хэлэлцүүлгийн индэр болжээ.

Хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр ОУИТБС-ын ач холбогдол, хэрэгжилтийг бүрэн, ямар ч хязгаарлалтгүйгээр, чөлөөтэй хэлэлцэж байна.

12. ОУИТБС-ын тайлангийн мэдээллийг ашиглан ажил хэрэгч маргааныг шийдвэрлэх тохиолдол нэг биш удаа гарч байна.

“Бороо гоулд” компаниас татвар төлсөн төлөөгүй маргааны үеэр ОУИТБС-ын тайлагнасан дүнг танилцуулж, маргааныг шийдвэрлэж байсан тохиолдол гарч байсан.

13. ОУИТБС-ын тайлан гаргахгүй байгаа компаниудтай хариуцлага тооцож байна.

2016 оны тайлангаа гаргаагүй 14 компани 58 сая төгрөгийн торгууль төлсөн байна.

Хэдийгээр Монгол Улс ОУИТБС-ыг 10 гаруй жил хэрэгжүүлж, дэлхийн эхний эгнээнд тэргүүлэх орны нэгээр үнэлэгдэж байгаа ч үр дүн хангалттай бус гэсэн үнэлгээг олон нийтийн зүгээс өгч байна. Иймээс ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа оролцогч талуудын идэвх, хариуцлагыг улам нэмэгдүүлэх нь зүй ёсны шаардлага болж байна.

1.3. Үндсэн гол үйл ажиллагаанууд-2017 он

Компаниуд, Засгийн газрын байгууллагуудын 2016 оны тайлагнал

Компани, Засгийн газрын байгууллагуудын 2016 оны тайлан гаргах ажлыг холбогдох төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Үүний үр дүнд ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 1227 компани тайлангаа (хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 642, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 574, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй 11 компани), Засгийн газрын харъяаны 7 агентлаг, 17 аймаг, 9 дүүргийн Засаг даргын тамгын газрууд нийт 2086 компаниас орлого хүлээн авсан тухай тайлангаа тус тус цахимаар 7 дугаар сар гэхэд гаргасан байна. Орлого хүлээн авсан байгууллага, дүүрэг, аймгуудыг танилцуулахад Ашигт малтмал, газрын тосны газар 1867, Татварын ерөнхий газар 1274, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 984, Гаалийн ерөнхий газар 277, Баянгол дүүрэг 144, Чингэлтэй дүүрэг 116, Дорноговь аймаг 106, Сүхбаатар дүүрэг 105, Сэлэнгэ аймаг 50 компаниас хүлээн авсан орлогоороо тайлан гаргасан байна. Бусад байгууллага, дүүрэг, аймгуудыг хавсралтаар харуулав. Энэ жилийн компанийн тайлагнал өмнөх оноос 64 хувиар өссөн байна.

2016 оны Баталгаажуулалтын дүн, зөвлөмжийг хэлэлцсэн байдал

ОУИТБС-ын Удирдах хорооноос 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын баталгаажуулалтын дүнг баталж, холбогдох зөвлөмж ирүүлсний дагуу 2 дугаар сард Ажлын хэсэг хуралдаж, засч сайжруулах ажлуудыг хэлэлцэж, зарчмын хувьд зөвшөөрч, ихэнх ажлыг Хараат бус хянан нэгтгэгчтэй хамтран хийхээр болж, хэрэгжүүлсэн байна. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой хурлын ирц, санал хураахтай нэмэлт өөрчлөлтүүдийг 11 дүгээр сард хүлээн авч, баталсан байна.

Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлан буюу 11 дүгээр тайлангийн удирдамжийг боловсруулсан байдал

2017 оны эхээр Ажлын хэсгийн гишүүдэд 11 дүгээр тайланг гаргах хараат бус хянан нэгтгэгчийг сонгон шалгаруулах болон ажиллах удирдамжийг цахимаар илгээж, санал авсаны үндсэн дээр батлуулж хэвлэн нийтлүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Үнэлгээний хороог Ажлын албан дээр байгуулан, хороог АМГТГ-ын ахлах мэргэжилтэн Ц.Цэгцээр ахлуулан, УУХҮЯ-ны санхүүгийн газрын мэргэжилтэн Н.Нямхүү, Монголын УУҮА-ийн ерөнхийлөгч Н.Алгаа, Бороо Гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Б.Болормаа, Байгаль орчины иргэний зөвлөлийн удирдах хорооны гишүүн Б.Батболд, Зориг сангийн ажилтан Б.Гансүх, Ажлын албаны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нарын бүрэлдэхүүнтэй ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргын тушаалын дагуу байгуулж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Мөн ОУИТБС-ын ОУНБДнГ-ын хариуцсан мэргэжилтнүүдээс энэ удирдамжийн төсөлд санал авч, холбогдох саналыг тусган, сонгон шалгаруулалтыг 1 дүгээр сард зарлан, эхлүүлсэн болно.

Сонгон шалгаруулалт, гэрээ байгуулсан нь

2016 оны ОУИТБС-ын тайлан гаргах Аудиторын түншлэлийн сонгон шалгаруулалтад КейПиЭмЖи аудит-Монгол, КейПиЭмЖи аудит-Франц Улаанбаатар аудит корпораци, Харт Нойрс, БДО, Од бүртгэл аудит, Сүлд аудит, Латана аудит, Голден пейж аудит, ЭсЖиЭмДи аудит, Моорс Стефенс компаниуд оролцсон байна. Сонгон шалгаруулалтаар Монгол, Франц улсуудын КейПиЭмЖи компаниудын консорциум шалгарч, гэрээт ажлаа 4 дүгээр сарын 24-нд эхлэж, эхлэлийн семинарыг 5 дугаар сард зохион байгуулж, Ажлын хэсэгт 6 дүгээр сард эхлэлийн тайлангаа танилцуулж ажилласан. Ажлын хэсэгт 11 дүгээр сард тайлангийн төслөө

танилцуулан, холбогдох дүгнэлтийн дагуу 12 дугаар сард Үндэсний Зөвлөлд танилцуулан батлуулав. Найруулга, тодруулгын шинжтэй засварыг 2018 оны 1 дүгээр сарын 15-ны дотор өгч, эцсийн болгоно.

Нэгтгэлийн үйл ажиллагаа

КейПиЭмЖи компаниудын Консорциум нь 2016 оны тайланг ОУИТБС-ын стандартын дагуу боловсруулж, тэргүүлэх 213 компанийн тайланг Засгийн газрын тайлантай тулган баталгаажуулж, холбогдох дүгнэлтүүдийг хийж, зөвлөмж гаргасан байна. Нэгтгэлийн үйл ажиллагаа 6 дугаар сард эхлэж, 11 дүгээр сар хүртэл үргэлжилсэн нь наадам, амралтын хугацаатай давхцах, эдгээрээс улбаалан, байгууллага компаниуд хариу өгөх ажил удаашралтай байсантай холбоотой ажээ.

11 дүгээр тайлангийн төслийг хэлэлцсэн байдал

КейПиЭмЖи компаниудын Консорциумаас тайлангийн төслийг Ажлын хэсэгт 11 дүгээр сард танилцуулж, хэлэлцүүлсэн бөгөөд Ажлын хэсгийн зүгээс дэмжлэг авсан. Мөн ОУНБДНГ-аас шүүмж ирүүлснийг хамтад нь хэлэлцэж, Үндэсний Зөвлөлд танилцуулж, батлуулахыг эцсийн хувилбарыг засч сайжруулах зөвлөмжийг өгсөний, засч сайжруулан танилцуулж байна.

Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын тухай

Олборлох салбарын аж ахуйн нэгжийн ашиг хүртэгч эздийг ил тод болгох “Замын зураг” хөтөлбөрийн дагуу 9 удаагийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрт 260 гаруй мэргэжилтнүүд оролцож санал дүгнэлтээ өгсний дүнд холбогдох нэр томъёо тодорхойлолтыг боловсруулан дуусган, Ажлын хэсэгт танилцуулан дэмжлэг авсны дүнд Засгийн газрын тогтоолд заасны дагуу ЗГХЭГ-т өргөн барьсан байна.

Сургалтууд

Жил бүр оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулж хэвшээд байна. Энэ жил баталгаажуулалтаар доогуур үнэлгээ авсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад 1, 5-р сард цуврал сургалтыг ХБХН КэйПиЭмЖи консорциум, Эрдэнэс МГЛ компанитай хамтран зохион байгуулсан.

2016 оны нэгтгэл тайлангийн анхны тайлагналын чанар, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагууд болон компаниудад зориулан 2, 4, 5, 6 дугаар саруудад тус тус цуврал сургалтуудыг зохион байгуулж, нийт 230 гаруй оролцогчид оролцсон байна. Гол сургагч багшаар Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Б.Болормаа уул уурхайн салбарт мөрдөгдөх НББ-ын стандартын тухай, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяр, зөвлөх Б.Аюуш нар компанийн засаглал, ил тод байдлын тухай, Олон улсын стандартын академийн гүйцэтгэх захирал П.Тунгалаг Компанийн нийгмийн хариуцлагын ISO:MNS 26000 стандарт, Авлигын эсрэг менежментийн ISO 37001 стандартын тухай, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа иргэдийн оролцооны тухай, 2015 оны ХБХН-ийг төлөөлж Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн аудитын зөвлөх Б.Эрдэнэцог, 2016 оны ХБХН-ийг төлөөлж КэйПиЭмЖи консорциумын менежер Ш.Номиндарь нар хичээл заасан байна.

5-р дугаар сард Үндэсний хөгжлийн газартай хамтран “Орон нутгийн төлөвлөгөөний ажилтнуудын чуулган”-ыг зохион байгуулж, мэдээлэл өгч, сургаж, орон нутгийн ажилтнуудыг чадавхийг нэмэгдүүлсэн байна.

Сэтгүүлчдэд зориулан ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг ашиглан хэрхэн олон нийтэд хүртээмжтэй нэвтрүүлэг, сурвалжлага бэлтгэх талаар чадавхийг бэхжүүлээ. Тухайлбал, Монголиан Майнинг Журналтай хамтран 21 аймгийн орон нутгийн 40 гаруй сэтгүүлчдийг

сургаж, сэтгүүлчдийн дунд уран бүтээлийн уралдааныг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж дүгнэсэн байна. Мөн Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран төвийн 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулж, тэдний мэдлэг чадавхийг нэмэгдүүлсэн байна.

Хоёр. 2017 оны Ажлын төлөвлөгөөгөөр тавьсан зорилгуудаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн

2.1. Нэгдүгээр зорилго: ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтын дүнгээр доогуур үнэлгээ авсан үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг ахиулах, Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж, үр дүнд хүрсэн байна.

1. Баталгаажуулалтын дүнгээр “тун хангалтгүй” үнэлгээ авсан Төрийн өмчийн компаниудтай холбоотой асуудлаар Эрдэнэс Монгол ХХК болон Төрийн өмчийн 7 компани, тэдгээрийн 45 удирдах албан тушаалтнууд, санхүүгийн удирдлагад зориулан 2015 оны нэгтгэл тайланг хийсэн Улаанбаатар аудит корпорац, 2016 оны нэгтгэл тайланг хийж буй КейПиЭмЖи консорциум, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүдтэй хамтран 2 удаа сургалт зохион байгуулж, тэдний мэдлэг ойлголтыг сайжруулсан байна.
2. КейПиЭмЖи консорциумтай хамтран 2 дахь сургалт дээр 2016 оны тайлангийн хамрах хүрээний чиглэл өгч, харилцан санал солилцож, ажлын даалгаврыг эцэслэн тохирсон байна. Улмаар Ажлын хэсгийн 6 дугаар сарын хуралдаанаар хамрах хүрээг эцэслэсэн болно.
3. Төрийн өмчийн компаниудын төсвийн шинжтэй зарцуулалт, шилжүүлгийн хүрээнд Эрдэнэт үйлдвэрээс төсвийн шинжтэй зарцуулалтын тайланг 2015 оны жишээн дээр танилцуулсан байна.
4. КейПиЭмЖи консорциумтай хамтран Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол ХХК-ийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, ОУИТБС-ын стандартын хүрээнд зарим мэдээллийг хэрхэн нийтэд тайлагнах талаар санал солилцож, судалгаа явуулсан байна.
5. Гэрээний ил тод байдлын хүрээнд Газрын тосны бүтээгдэхүүнийн 24 гэрээний солбилцлыг 2016 оны нэгтгэл тайланд оруулсан байна.
6. Сангийн сайдын 2016 оны 43-р тушаалаар ОУИТБС-ын тайлангийн маягтыг шинэчлэн батлахдаа байгаль орчны мэдээллийг авахаар маягтад оруулж өгсөн. Маягтын дагуу 166 компаниуд тайлагнасан байна.
7. Мэдээллийг баталгаажуулах хүрээнд Засгийн газрын ОУИТБС-ын тайланг баталгаажуулах журмыг боловсруулах ажлыг Үндэсний аудитын газраас 2017 оны ажлын төлөвлөгөөнд оруулж, журмын төслийг хэлэлцэж байна.
8. 2016 оны нэгтгэл тайлангийн компаниудын мэдээллийг баталгаажуулах хүрээнд КейПиЭмЖи компаниудын консорциум аргачлал гаргаж, Ажлын хэсэгт 6 дугаар сард танилцуулан, ойлгуулж, зөвшөөрсний үндсэн дээр судалгаа хийж, 11 дүгээр сард танилцуулахад баталгаажуулалтын түвшин өмнөх 2014-2015 онуудын үзүүлэлттэй харьцуулахад сайжирсан байна.
9. Төрийн байгууллагуудад зориулсан 2-р сарын сургалтад төрийн захиргаа, нийслэлийн дүүргийн татварын 25 байгууллагын 32 удирдах албан тушаалтнууд оролцож, чадавх нэмэгдсэн байна.

10. 2017 оны 12 дугаар сард төвийн бүсийн 6 аймгийн дарга нарын сургалт семинарыг зохион байгуулж, 2018 онд Аймгуудын ОУИТБС-ын дэд зөвлөлийн хийх ажлуудыг төлөвлөсөн байна.
11. 2016 оны 12-р сард төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан. Зарим төрийн байгууллагуудын удирдлагуудтай /АМГТГ, ТЭГ, ҮХГ, YAГ/ тус бүр уулзалт зохион байгуулж, харилцаа холбоог сайжруулан ажиллаж байна.
12. 2017 оны 6 дугаар сарын Ажлын хэсгийн хуралдаанаар 222 дугаарт тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн баталж, Засгийн газарт хүргүүлсэн. Тогтоолын нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 9 сард Засгийн газраас баталсан.
13. Авилгатай тэмцэх 2017-2023 оны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ОУИТБС-ын стандарт, Ашиг хүртэгч эздийг ил болгох ажлыг оруулсан бөгөөд төлөвлөгөөг Засгийн газрын тогтоолоор баталсан байна.
14. УУХҮЯ-наас боловсруулсан Уул уурхайн тухай хуулийн төсөлд бүлэг болгон тусгаж, холбогдох журмын дагуу оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг хийгдэж байна.
15. 2015 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн 7.2.6-ийн 3-д цахим тайлагналын системийн SSL сертификаттай болгох зөвлөмжийн дагуу холбогдох сертификатыг авсан.

Энэ зорилгыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

1. ТӨК-иудын тайлан гаргадаг ажилтнууд мэдлэг, ойлголт нэмэгдэж, ТӨК-иудийн ил тод болгох төлбөр, шилжүүлгийн цар хүрээ тодорхойлогдож, зөвлөмж, заавар бэлэн болсон байна.
2. 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн байна.
3. Тусгай зөвшөөрлийн ил тод байдал ОУИТБС-ын стандартын хүрээнд бүрэн хангагдсан байна.
4. 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн байна.
5. Нөхөн сэргээлтийн мэдээлэл ААН бүрээр боловсруулагдсан байна.
6. Үндэсний зөвлөлийн 15-р хуралдааны шийдвэрийн 6в хэрэгжсэн байна.
7. Мэдээллийн найдвартай байдал нэмэгдсэн байна.
8. Орлогын хуваарилалтын мэдээллийн боловсруулалт дэлгэрэнгүй болсон байна
9. Мэдээллийн боловсруулалт сайжирсан байна.
10. Ажлын төлөвлөгөөнүүд хоорондоо уялдсан байна.
11. Төрийн байгууллагуудын хурлын ирц нэмэгдсэн байна.
12. Гишүүдийн үүрэг, хариуцлага тодорхой болсон байна.
13. Эрх зүйн орчин тодорхой болж, гүйцэтгэх засаглал мөн нутгийн өөрөө удиргах байгууллагын чиг үүрэг тодорхой болсон байна.
14. Тодорхой асуудлаар ажиллаж АТГ, YAГ анхаарал хандуулах замаар оролцоо нь бий болж мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.
15. Олон нийтийн сүлжээний дагагчдын тоо нэмэгдсэн байна.
16. Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь хэмжээ нэмэгдсэн байна.
17. Стандартын талаар компаниудын мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.
18. 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн болон хэрэгжих шатандаа байна

2.2. Хоёрдугаар зорилго: Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэл тайланг боловсруулах, батлах хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. 2016 оны нэгтгэл тайланг боловсруулах Хараат бус хянагч-нэгтгэгчийг сонгон шалгаруулалт 2-3 дугаар саруудад амжилттай явагдаж, 4-р сард КейПиЭмЖи консорциум сонгогдож гэрээ байгуулж, ажил эхлэсэн.

2. Зөвлөх үйлчилгээ гэрээний үнийн дүн 190 сая төгрөг болж, төсөвт хөрөнгийг хэмнэсэн. Эхний 30 хувийг 6 дугаар сар, 60 хувийг 12 дугаар сард төлсөн. Үлдэгдэл 10 хувийг 12 дугаар сарын эцсээр Үндэсний зөвлөл батласны дараа төлж барагдуулав.
3. Гар утас, имэйл, вэбсайт, өдөр тутмын сонингоор тайлан гаргах тухай зарыг удаа дараа илгээн нийтэлж, мэдээлж ажилласан. АМГТГ-ын мэдээллийн самбарт зар тавьж мэдээлэл түгээсэн байна.
4. Тайлан гаргасан компаниудын нэрсийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлж, тайлан гаргаагүй компаниудтай хариуцлага тооцох ажлыг хэрэгжүүлж байна.
5. Ажлын хэсгийн 6 дугаар сарын хуралдаанаар нэгтгэлд хамрагдах тэргүүлэх 213 компаниудын нэрсийг гаргаж, шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байна.
6. Ажлын хэсэг 11 дүгээр сард тайлангийн төслийг хэлэлцэн Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулахыг зөвшөөрсөн байна. Үндэсний Зөвлөл 12 дугаар сарын 21-ний өдөр зарчимын хувьд баталсан байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

1. Нэгтгэл тайлан батлагдсан.
2. Тайлагнагч байгууллагуудын чадавх нэмэгдэж, анхлан тайлагнагч компаниудын тоо өмнөх оноос 64 хувиар өссөн байна.
3. 2015 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн болон хэрэгжих шатандаа байна.
4. Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн.

2.3. Гуравдугаар зорилго: ОУИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. ЕСБХБ-ны санхүүжилтээр ОУИТБС-ын орон нутгийн мэдээлэл, харилцааг сайжруулах туршилтын төсөлд хамрагдах сумдын судалгааг холбогдох шалгууруудын хамт боловсруулан, Ажлын хэсэгт танилцуулан батлуулж үйл ажиллагааг 3-р сараас эхлэн хэрэгжүүлж байна. Туршилтын хөтөлбөрт Төв аймгийн Заамар, Өмнөговь аймгийн Гурвангтэс, Сэлэнгэ аймгийн Ерөө, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумдууд хамрагдаж байна.
2. Эдгээр сумдад 3 дугаар сард хэрэгцээний үнэлгээ хийж, 6-р сард мэдээлэл харилцааны стратеги боловсруулан Ажлын хэсгийн хурлаар батлуулж, 7-р сараас идэвхтэй үйл ажиллагааг хэрэгжүүлээ. Гарч буй үр дүнгээс дурьдвал:
 - a. 4 сум төр, компани, иргэний тэнцүү төлөөлөл бүхий Дэд зөвлөлөө шинээр эмхлэн байгуулж, чадавх бэхжүүлэх сургалтанд хамрагдаад байна. Ихэнх сумд дэд зөвлөлийг асуудлыг шийдвэрлэх нэгэн чухал механизм гэж харж байна. Жишээ нь Өмнөговь аймгийн Гурвантэс сум гэхэд дэд зөвлөлөөр дамжуулан орон нутагт үүсээд буй үл ойлголцлыг шийдвэрлэх үүднээс хамтран ажиллаж, орон нутгийн худалдан авалт (мах, сүү, хүнсний ногоо), ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хүчин чадлын судалгаа хийж, гэрээ байгуулахаар харилцан ойлголцоод явж байна.
 - b. Сум бүрт Мэдээллийн ажилтны орон тоо бий болгож, Мэдээллийн төв/буланг тохижуулан, төвөөс удирдлагаар ханган чадавхийг бэхжүүлэн иргэдэд идэвхтэй мэдээллийг түгээн ажиллаж байна. Жишээ нь Хэнтий аймгийн Бор-өндөр сумын дэд зөвлөлийн гишүүн бүр ээлжлэн мэдээллийн төвдөө ажиллаж, санал, гомдол хүлээн авч, шаардлагатай мэдээллийг түгээж байна. 5 мэдээллийн ажилтнуудын 2 нь байгаль хамгаалагч бөгөөд уул уурхайн асуудлаар өдөр тутам тулж ажилладаг байна. Мэдээллийн ажилтнууд БИНХ, Засаг даргын тайлангийн хурал зэрэг томоохон арга хэмжээнүүдэд оролцон ОУИТБС-ыг сурталчлан ажиллаж байна.

- с. Мэдээлэл харилцааны шинэлэг арга, техникуудыг ашиглан иргэдэд ОУИТБС-ын тайлангийн хүрээнд ил тод болсон мэдээллийг үр дүнтэй хүргэж байна. Тухайлбал мал тооллогоор малчин өрх бүрт уншвартай сонин түгээх, гар утсанд мессеж, АХА, Спорт өдөрлөг гэх мэт хөгжөөнт арга хэмжээг зохион байгуулж уул уурхайн хүнд сэдвийг иргэдэд оновчтой хүргэх, ЕБС-ын төгсөх ангийн сурагчидтай уулзалт, ярилцлага хийж, хүүхэд, залуусын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, лого бүтээх, зохион бичлэгийн гэх зэрэг уралдаан зарлаж идэвхжүүлэх, сум бүрийн фэйсбүүк групп-ээр дамжуулан инфографик бүхий постерууд түгээх, Багийн иргэдий нийтийн хуралд оролцож мэдээлэл хийж байна.
3. Туршилтын 5 сумын дэд зөвлөлийн гишүүд, мэдээллийн ажилтнуудад зориулсан чадавх бэхжүүлэх сургалтыг 10 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулж, цэгцтэй ойлголт өгч ажиллаа. Сургалтаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, 2017 оны 10 дугаар сарын 22-ноос “Ил тодын жишиг сум болцгооё” сэдэвт 2 сарын аяныг зарлан идэвхжүүлэлтийн арга хэмжээ авч байна. Тэргүүн байр эзэлсэн дэд зөвлөлд Ерөнхий сайдын нэрэмжит цом гардуулахаар төлөвлөж байна.
4. 2017 оны 5 дугаар сард Үндэсний зөвлөлийн гишүүн, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгааг Увс аймгийн олборлох үйлдвэрлэлийн чуулганд оролцож, төв, орон нутагт хэрэгжүүлж байгаа ажлыг танилцуулж, мэдээлэл түгээсэн байна. Үр дүнд нь Увс аймгийн ОУИТБС-ын Дэд зөвлөлийг шинэчлэн, үйл ажиллагаагаа сэргээсэн байна.
5. 2017 оны 3 дугаар сард Дундговь аймгийн Өлзийт сумын ОУИТБС-ын дэд зөвлөлийн чуулганыг зохион байгуулж, орон нутагт мэдээлэл түгээн, туршлага солилцож, оролцогч талууд чадавхтай болж, туршилтын төслийн сумдад танилцуулгыг хийлгэсэн байна.
6. Ажлын хэсгээс оруулсан саналыг хүлээн авч, Засгийн газрын 2017 оны 263-р тогтоолоор 2019 оноос дэд зөвлөлийн зардлын санхүүжилтыг улсын болон орон нутгийн төсвөөс гаргахаар болсон байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

1. Төсөл хэрэгжиж буй 5 суманд ОУИТБС-ын хэрэгжилт, харилцаа холбоо идэвхжсэн.
2. Аймгийн түвшинд мэдлэг ойлголт нэмэгдэж, чадавх бэхжсэн.
3. Дэд зөвлөлийн санхүүжилтын боломжийг судалж, 2019 оноос улс болон орон нутгийн төсвөөс гаргахаар болж, шийдвэрлэсэн.

2.4. Дөрөвдүгээр зорилго: Ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох замын зургийн 2017 онд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд:

1. Нээлттэй засгийн үндэсний зөвлөлд 6 дугаар сард ОУИТБС, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлаар танилцуулга хийж, үйл ажиллагаагаа уялдуулах талаар зарчмын хувьд тохирсон байна.
2. УУХҮЯ-тай хамтран 6 дугаар сард Ашиг хүртэгч эздийг ил тод болгохтой холбогдуулан 10 гаруй төрийн байгууллагуудын 17 албан тушаалтныг урьж, уулзалтыг зохион байгуулж, танилцуулга хийж, мэдээлэл өгөхийн хамт, хамтран ажиллах асуудлаар санал солилцов. Нэр томьёо, тодорхойлолтын талаар саналуудыг авч нэгтгэв.
3. ЕСБХБ-ны санхүүжилтээр ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын техник туслалцаа бүхий шинэ төслийг ОУИТБС-ын Ажлын хэсэг болон ашиг хүртэгч эздийг ил тод болгох дэд хэсэгт танилцуулж, тэдний саналыг Олон Улсын нарийн бичгийн дарга нарын газарт санал солилцов. Энэ шинэ төслийг 2018 онд шинэчлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.
4. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийн тайлагналыг хэсгийг Уул уурхайн тухай хуулийн төсөлд бүлэг болон тусгагдсан бөгөөд энэ дотроо

- ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаар хуулийн заалтыг УУХҮЯ-ын ажлын хэсгээс оруулан хэлэлцүүлж байна.
5. Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаархи дотоод, гадаад мэдээллийн санг 12 дугаар сард бий болгож байна.
 6. 2 дугаар сард компаниудын санхүүгийн ажилтнуудад /50 хүн/, 4 дүгээр сард захирал, санхүүгийн ажилтнуудтай /24 хүн/ Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаархи хэлэлцүүлэг зохион байгуулж, нэр, томъёо тодорхойлолтын талаархи саналуудыг нь авч нэгтгэсэн байна.
 7. Тэргүүлэх 30 компанийн хуулийн зөвлөх, захирлуудыг урьж 5 дугаар сард /14 хүн/ Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаар хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусгасан авч тусгасан байна.
 8. Мөн 2, 6 дугаар саруудад төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаархи хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг тусгасан. /52 хүн/
 9. Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаар Ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн гишүүн иргэний нийгмийн байгууллагуудын хэлэлцүүлгийг 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулж, тэдний саналуудыг нэгтгэн тусгасан байна. 11-р сарын 15-ны өдрийн Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулна.
 10. Ажлын хэсэгт 11 дүгээр сард нэр томъёо, тодорхойлолтыг нэгтгэн, эцэслэн боловсруулж, батлуулсан. Холбогдох Засгийн газрын тогтоолын дагуу ЗГХЭГ- т эдгээр саналуудыг хүргүүлсэн байна. Тогтоол ёсоор Хууль зүй дотод хэргийн яам, Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас 12 дугаар сард багтаан хуулийн төслийг Үасгийн газрын хуралдаанд танилцуулах ёстой билээ.
 11. Уул уурхайн ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлыг Монголын Үндэсний телевизээр 12 дугаар сарын сүүлээр хэлэлцүүлэг зохион байгуулж, нэвтрүүлэн өргөнг олонд хүргэв.

Энэ зорилгыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

1. Хамтарч хэрэгжүүлэх ажлууд тодорхой болсон.
2. Сонирхогч талууд нэгдсэн ойлголттой болсон.
3. Тогтсон нэр томъёотой болсон.
4. Туршлага судлах мэдээллийн баазтай.
5. Санал, ойлголт ерөнхийдөө нэгдэж, Талууд зөвшилцөж байна.
6. Компаниудын хүлээн авах байдал сайжирч, харилцан ойлголцол нэмэгдсэн.
7. Олон нийтийн мэдлэг, ойлголт, оролцоо нэмэгдсэн.

2.5. Тавдугаар зорилго: Гэрээний ил тод байдлыг хангах хүрээнд дараах ажлуудыг хийв.Үүнд:

1. Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр www.iltodgeree.mn гэрээний цахим санг байгуулан, албан ёсны нээлтийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яамтай хамтран зохион байгуулсан байна.
2. Нээлтийн үеэр ил тод гэрээний цахим санг ажиллуулах, баяжуулах асуудлаар хамтран ажиллах санамж бичгийг УУХҮЯ, ННФ, Ажлын алба байгуулж, албажуулсан байна. Одоогоор уг гэрээний санд нийт 35 гэрээний эх бичвэрүүдийг байршуулж, холбогдох туслах мэдээлэл, тайлбаруудыг хамтад олон нийтэд зориулан байршуулсан байна.
3. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс 2017 онд гэрээний хэрэгжилтэнд тавих мониторингийн сургалтыг зохион байгуулж, энэ ажлын хүрээнд орон нутгийн хамтын ажиллагааны 10 гэрээнд хяналт хийж, дүн гаргасан байна.
4. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох асуудлын хүрээнд бүх гэрээг гэрээний шинэ маягтад оруулах ажил хийгдэж байна. Гэрээний маягт ил тод болсон байна.

5. Гэрээ байгуулах үйл явцыг ил тод болгох зорилгоор Өмнөговь аймгийн Гурвантэс суманд гэрээ байгуулахаас өмнө талуудын чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

1. Гэрээний сан бүрдэж, цахим сайт ашиглалтанд орсон.
2. Гэрээнд мониторинг хийх чадавх бэхжсэн.
3. Гэрээнүүд тодорхой хэмжээнд ил болсон.

ГУРАВ. ОУИТБС-ЫН ШААРДЛАГА БҮРИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ

3.1. 2016 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх

Монгол Улс ОУИТБС-ын стандартын шаардлагуудыг хангасан эсэх талаар ОУИТБС-ын Удирдах хороо 2017 оны 1 дүгээр сард “мэдэгдэхүйц ахицтай” гэсэн шийдвэрийг гаргасан байна.

Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016/		Шаардлага бүрийг хангасан байдал	
Ангилал	ОУИТБС-ын стандартын шаардлагууд	Дугаар	Хангалттай/гүй
ОУИТБС-ын үйл ажиллагаа, оролцоо, хяналт	Засгийн газрын оролцоо	1,1	Хангалттай
	Компанийн оролцоо	1,2	Хангалттай
	Иргэний нийгмийн оролцоо	1,3	Хангалттай
	Олон талт бүлгийн удирдлага, үйл ажиллагаа	1,4	Хангалтгүй
	Ажлын төлөвлөгөө	1,5	Хангалттай
Тусгай зөвшөөрөл, гэрээнүүд	Эрх зүйн орчин	2,1	Хангалттай
	Тусгай зөвшөөрлийн олголт	2,2	Хангалтгүй
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл	2,3	Хангалтгүй
	Гэрээ хэлэлцээр, тэдгээрийг ил тод болгох бодлого	2,4	Хангалттай
	Бенефициарь өмчлөгч	2,5	Шаардлагагүй
	Төрийн оролцоо, эзэмшил	2,6	Тун хангалтгүй
Олборлолт, хяналт	Хайгуулын мэдээлэл	3,1	Хангалттай
	Олборлолтын мэдээлэл	3,2	Хангалттай
	Экспортын мэдээлэл	3,3	Хангалттай
Орлого төвлөрүүлэх	Иж бүрэн байдал	4,1	Хангалттай
	Мөнгөн бус орлого	4,2	Шаардлагагүй
	Бартерын хэлцэл	4,3	Шаардлагагүй
	Тээвэрлэлтийн орлого	4,4	Хангалттай

	Төрийн өмчит компаниудын шилжүүлэг	4,5	Хангалтгүй
	Орон нутагт шууд төлдөг төлбөр	4,6	Хангалттай
	Задаргааны түвшин	4,7	Хангалттай
	Мэдээллийн цаг хугацаа	4,8	Хангалттай
	Мэдээллийн чанар	4,9	Хангалтгүй
Орлогын хуваарилалт	Орлогын менежмент, хуваарилалт	5,1	Хангалттай
	Орон нутгийн шилжүүлэг	5,2	Хангалтгүй
	Орлогын зарцуулалт	5,3	Шаардлагагүй
Нийгэм эдийн засгийн хувь нэмэр	Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1a	Хангалтгүй
	Сайн дураар тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1b	Шаардлагагүй
	Төрийн өмчит компаниудын нийгмийн зарцуулалт	6,2	Тун хангалтгүй
	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	6,3	Сайн
Үр дүн, үр нөлөө	Олон нийтийн хэлэлцүүлэг	7,1	Хангалттай
	Мэдээллийн хүртээмж	7,2	Шаардлагагүй
	Зөвлөмжүүдийн биелэлт	7,3	Хангалттай
	Үр дүн, үр нөлөө	7,4	Хангалтгүй

“Хангалтгүй, тун хангалтгүй” хэмээн үнэлэгдсэн шаардлагуудын биелэлтийг сайжруулах зорилгоор Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс 2016 оны нэгтгэл тайланг боловсруулах сонгон шалгаруулалтын ажлын даалгаварт нэмэлт ажлуудыг оруулж, сонгон шалгарсан КейПиЭмЖи консорциумтай байгуулсан гэрээ болон эхлэлийн семинараар холбогдох ажлуудыг тохиролцон хийлгүүлсэн байна.

Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт ажил болох Ажлын хэсгийн хурлын ирцийг баталгаажуулах зорилгоор оролцогч тал бүрээс 6-аас доошгүй байх гишүүд ирснээр хурал хүчинтэй болох, санал зөрөлдөөд санал хураах бол оролцогч тал бүрийн 2/3 –ын саналыг авсан тохиолдолд тухайн асуудал шийдэгдэхээр шийдвэрлэсэн байна.

Дөрөв. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тоймыг дараах 2 хүснэгтээр харуулав. Үүнд:

4.1. Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016

Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016/		Шаардлага бүрийг хангасан байдал	
		Дугаар	Хангалттай/гүй
Ангилал	ОУИТБС-ын стандартын шаардлагууд		
ОУИТБС-ын үйл ажиллагаа, оролцоо, хяналт	Олон талт бүлгийн удирдлага, үйл ажиллагаа Ажлын хэсэг, Үндэсний Зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. Компани, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг сонгох томилох журамтай болсон.- ХАНГАЛТТАЙ	1,4	Хангалтгүй
Тусгай зөвшөөрөл, гэрээнүүд	Тусгай зөвшөөрлийн олголт	2,2	Хангалтгүй
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл	2,3	Хангалтгүй
	Төрийн оролцоо, эзэмшил	2,6	Тун хангалтгүй
КейПиЭмЖи компанитай хамтран ажиллаж холбогдох мэдээлэл, үнэлгээг 2016 оны нэгтгэл тайланд оруулсан- ХАНГАЛТТАЙ			
Орлого төвлөрүүлэх	Мэдээллийн чанар	4,9	Хангалтгүй
	КейПиЭмЖи компанитай хамтран ажиллаж холбогдох мэдээлэл, үнэлгээг 2016 оны нэгтгэл тайланд оруулсан- ХАНГАЛТТАЙ		
Орлогын хуваарилалт	Орон нутгийн шилжүүлэг	5,2	Хангалтгүй
	КейПиЭмЖи компанитай хамтран ажиллаж холбогдох мэдээлэл, үнэлгээг 2016 оны нэгтгэл тайланд оруулсан- ХАНГАЛТТАЙ		
Нийгэм эдийн засгийн хувь нэмэр	Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1a	Хангалтгүй
	Төрийн өмчит компаниудын нийгмийн зарцуулалт	6,2	Тун хангалтгүй
КейПиЭмЖи компанитай хамтран ажиллаж холбогдох мэдээлэл, үнэлгээг 2016 оны нэгтгэл тайланд оруулсан- ХАНГАЛТТАЙ			
Үр дүн, үр	Үр дүн, үр нөлөө	7,4	Хангалтгүй

нөлөө Үр дүн, үр нөлөөний байдлыг энэ тайланд² оруулсан- ХАНГАЛТТАЙ

4.2. Өмнөх жилийн тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт ША 7.3 /2015 оны тайлангийн/

Зөвлөмжүүд	МОҮИТБС-ын 2015 оны Нэгтгэл тайлангийн заалт	Хэрэгжсэн байдал
Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох	7.2.1	Хэсэгчлэн хэрэгжсэн
Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл: <ul style="list-style-type: none">- Тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдлын талаарх стандартын хамгийн наад захын шаардлагыг хангуулах- АМГТГ-аас гаргаж буй тусгай зөвшөөрлийн статистик мэдээллүүдийн нийцэлтэй байдлыг хангах	7.2.2	Хэрэгжсэн
ТӨААН-үүд нөхөн сэргээлтийн зохистой, иж бүрэн төлөвлөгөөтэй болох	7.2.3	Хэсэгчлэн хэрэгжсэн
СЯ болон ТӨААН-үүдийн аудитын тайлангийн хязгаарлалттай дүгнэлтийн талаар ОТАХ ярилцах	7.2.4	Хэсэгчлэн хэрэгжсэн
Баталгаажуулалт: <ul style="list-style-type: none">- Засгийн газар: ОҮИТБС-ын мэдээллийн баталгаажуулалтад ҮАГ-ыг оролцуулах- Компаниуд: Компаниудын зүгээс аудитлагдсан санхүүгийн тайлангаа танилцуулах үйл ажиллагааг сайжруулах талаар зохистой арга хэмжээг авах- Удирдлагын батлагаажуулалт: Компаниудын зүгээс удирдлагын төлөөллийн захидлыг илгээх үйл ажиллагааг сайжруулах талаар зохих арга хэмжээ авах	7.2.5	Хэсэгчлэн хэрэгжсэн
Цахим тайлагналын систем <ul style="list-style-type: none">- Цахим тайлагналын системийн хэрэглээ: Тайлагнагч компаниуд	7.2.6	Хэрэгжсэн

² Энэ тайлангийн 3-4 дүгээр хуудас дээр байгаа болно.

болон төрийн байгууллагуудыг цахим тайлагналын системд мэдээллээ тайлагнах байдлыг нэмэгдүүлэх

- Олборлох үйлдвэрлэлийн бус компаниуд: Цахим тайлагналын систем хэрэглэгч компаниудыг шалгаж, олборлох үйлдвэрлэлийн бус компаниудыг хасах
- Мэдээллийн технологийн ерөнхий хяналт (МТЕХ): Цахим тайлагналын системийн МТЕХ-тай холбоотой тодорхой зөвлөмжүүд

Хараат бус хянагч нэгтгэгчийг эрт томилох

7.2.7

Хэрэгжсэн

Төслийн түвшин дэх тайлагнал

7.2.8

Эхлэлийн байдалтай байна.

Тав. Монгол Улсад 2017 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд үүссэн бэрхшээл, хариу арга хэмжээ, авсан сургамж

1. Монгол Улсын ОУИТБС-ын 11 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо нэмэгдсэн ч тайлан гаргахгүй байгаа компанийн тоо өндөр хэвээр байна. Тооцоогоор 1000 орчим компани тайлангаа гаргахгүй байгаа нь 2017 оны 7 дугаар сарын 1- нээс хүчин төгөлдөр болсон “Захиргааны зөрчлийн тухай” хуулиар 10 сая төгрөгийн торгууль хүлээж байна. Гэвч зарим компанийн төлөөлөл торгуулийг хүлээн зөвшөөрөхгүй, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ажлын албаны хооронд үл ойлголцол үүсгэж байна.
2. Засгийн газрын байгууллагуудаас, тухайлбал Гаалийн ерөнхий газар Хянан нэгтгэгчид тодруулга тайлбар гаргаж өгөх ажилд хойрго хандсан хэвээр байна. Энэ асуудлыг цаашид эрхзүйг тодорхой болгох шийдвэрлэх хэрэгтэй байна.
3. Нэгтгэл тайлангаар гарсан мэдээллийн ашиглалт төдийлөн сайн биш байна. Цаашид нэгтгэл тайлангийн ашиглалтыг сайжруулах, зорилтот бүлгүүдэд зориулан амар хялбар ойлгохуйц хэлбэрээр хэвлэн нийтлэх, холбогдох сургалт сурталчилгааны ажлыг улам идэвхжүүлэх хэрэгтэй байна.
4. Монгол Улсын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгдсөн зарим ажил, үйл ажиллагааг олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож буй уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна. Ингэснээр мэргэжлийн байгууллагуудын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх боломжтой болно.
5. Засгийн газрын байгууллагуудын оролцоо харьцангуй сайн байгаа ч, холбогдох байгууллагуудын дээд шатны удирдлагын оролцоо хангалтгүй байна. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийн ирц хангалтгүй, орлож ирэх үзэгдэл оршоор байна. Цаашид энэ үзэгдлийг цэгцлэхэд ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж буй орнуудын туршлагыг судлах, практикт нэвтрүүлэх хэрэгтэй байна.
6. Компаниуд, тэдний төлөөллийн оролцоо хангалтгүй, идэвхгүй хэвээр байна. Ялангуяа, манлайлал болохуйц томоохон компаниудын захирлууд, хуулийн удирдлагын оролцоо идэвхгүй байна. ОУИТБС-ын тайлангаа гаргахгүй байгаа компаниуд олон хэвээр байна.
7. Аймаг нийслэл, сум дүүргийн түвшинд ОУИТБС түүний шинэ бодлого, нэгтгэл тайлангийн мэдээллийг боловсруулж хүргэх, тэнд байгаа институцийг чадавхжуулах, эрхзүйн болон санхүүгийн орчныг баталгаажуулах, удирдамж чиглэлээр хангаж ажиллах шаардлага хэвээр байсаар байна. Сонгууль болгоны дараа холбогдох ажил хариуцсан албан тушаалтнууд солигдож байгаа нь залгамж байдал алдагдаж, цаг алдахад хүргэж байна. Иймд тогтвортой суурьшилтай ажиллах нөөц бололцоог хангаж ажиллах их чухал байна.

Зургаа. Зарцуулалтын тайлан

2017 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлсэн зардал			
ОУЗСТөслийн ажлын алба			2017,12,21-ны байдлаар
Зардал	Төлөвлөгөө	Зарцуулалт	Эх үүсвэр
	төгрөг	төгрөг	
Ажлын хэсгийн гишүүдэд зориулсан сургалт, семинар	2 500 000	2 301 960	Дэлхийн банк
ОУИТБС-ын 11 дэх удаагийн тайлан гаргах Хараат бус хянан нэгтгэгчийн зөвлөх үйлчилгээ	230 000 000	190 000 000	Улсын төсөв
Ашиг хүртэгч эздийг ил тод болгох сургалт, семинар	10 000 000	7 236 053	Дэлхийн банк
ОУИТБС-ын бичиг баримтын орчуулга	2 000 000	1 693 000	Дэлхийн банк
ОУИТБС-ын 11 дэх удаагийн тайлан хэвлэх	3 500 000	3 500 000	Дэлхийн банк
Иргэний нийгмийн байгууллагатай хийсэн зөвлөх үйлчилгээний гэрээ	10 000 000	8 277 400	Дэлхийн банк
ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын уулзалтад оролцогчдын томилолтын зардал	10 000 000	1 966 400	Дэлхийн банк
ОУИТБС-ын гишүүнчлэлийн төлбөр	24 430 000	24 430 000	Улсын төсөв
ОУИТБС-ын удирдлагын зардал			
Сургалт, семинарын зардал	45 000 000	33 008 033,73	Дэлхийн банк
Ажлын албаны цалин хөлс, НДШ	208 191 600	208 191 600	Дэлхийн банк
Үйл ажиллагааны зардал (байрны түрээс, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, зар суртчилгаа)	55 000 000	48 131 835,66	Дэлхийн банк
Зардлын дүн	600 621 600	528 736 282	

Долоо. Хурал үйл ажиллагаанд оролцсон байдал, туршлага солилцох, хурлуудын ирц³

Үндэсний зөвлөл

Үндэсний зөвлөлийн 16 дугаар хуралдаан 2017 оны 12 дугаар сарын 21- ний өдөр хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

1. Монгол, Францын “КиПиЭмЖи” компаниудын консорциумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр нэгтгэл тайланг зарчмын хувьд батлав. Тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв. Энэ тайланг 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан,

³ Ирцийг тусад нь хавсаргав.

- 2018 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2017 оны 12 дугаар сарын 31- ний дотор хүргүүлэхийг Ажлын албанд даалгав.Тайлангаар өгөх зөвлөмжүүдээ тодорхой ойлгомжтой болгох, тайланг хэл найруулгын хувьд засч 2018 оны 1 дүгээр сарын 15- ны дотор Ажлын хэсэгт танилцуулахыг сайжруулах Монгол, Францын “КиПиЭмЖи” компаниудын консорциумд санал болгов. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав. Гэрээт ажлын үлдэгдэл мөнгийг “КиПиЭмЖи” компаниудын консорциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв. Монгол Улсын 2016 оны тайланг УИХ- ын Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороо болон Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын албанд даалгав.
2. Монголын ОУИТБС- ын 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2018 оны ажлын төлөвлөгөөтэй танилцаж, гишүүдээс гаргасан саналын хамт батлав. Монголын ОУИТБС-ын 2017 үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайланг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов. Ахиц дэвшлийн тайланд Компани, Иргэний нийгмийн товч танилцуулгыг 12 дугаар сарын 28-наас өмнө Ажлын албанд ирүүлэхийг Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, Иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” эвсэл, Монголын байгаль орчны иргэний зөвлөлд санал болгов. 2017 оны ажлын төлөвлөгөөнөс хийгдээгүй ажлуудыг 2018 онд хэрэгжүүлж, явцыг Ажлын хэсэгт эхний хагас жилд танилцуулж байхыг Ажлын албанд даалгав.
 3. “Ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох замын зураг-2020 он” төлөвлөгөөний биелэлтийн явц, шинэчилсэн төлөвлөгөөг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов. Төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэгт даалгав.
 4. Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоолын хэрэгжилтийг сайжруулах, ҮЗ-өөс зөвлөмж чиглэл гаргах тухай: Үндэсний зөвлөлөөс өгөх зөвлөмжийг боловсруулах Ажлын дэд хэсгийг УУХҮЯ- ны уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулан байгуулахаар шийдвэрлэв. Бүрэлдэхүүнд оролцогч тал бүрээс 2 хүн байхаар тогтов. Иргэний нийгмийн төлөөллөөс “Төлсөн авснаа нийтэл” эвслийн зохицуулагч, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан нар өөрсдийн саналаар бүрэлдэхүүнд орохоор болов.
 5. Үндэсний зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлтийг гишүүдийн саналын үндэслэн батлахаар тогтов.

Ажлын хэсэг

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2017 оны 2, 6, 11 дүгээр саруудад нийт 3 удаа хуралдав.

Ажлын хэсгийн 43 дугаар хуралдаан 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Сангийн яаман дээр болсон. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. Төсөл хэрэгжүүлэгч Адам Смит байгууллагаас санал болгосон дараах 5 сум: Төв аймгийн Заамар, Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэлэнгэ аймгийн Ерөө, Хэнтий аймгийн Дархан, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумдыг дэмжихээр тогтов.
2. Дурдсан 5 сумтай хил залгаа сумдын, ялангуяа Адам Смит байгууллагын төслийн багийн шалгуур үзүүлэлтийг танилцуулсанаар өндөр оноо авсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ОУИТБС-ын дэд зөвлөлийг туршилтын төсөлд оролцуулж, зохион байгуулах арга хэмжээнд хамруулахыг шийдвэрээр зөвлөмж болгов.
3. Оролцогч тал бүрээс тус бүр 3 гишүүн орсон Ажлын дэд хэсгийг байгуулахаар тогтов. Оролцогч тал бүр дэд хэсэгт орох өөрийн төлөөллийн нэрсээ 3 дугаар сарын 6-ны дотор Ажлын албанд ирүүлнэ.
 - a. Дэд хэсгийн хийх ажлын үндсэн үүрэг:
 - Монголын ОУИТБС-ын 2016 оны баталгаажуулалт дүнгийн талаар Олон улсын Удирдах хороо болон 2015 оны нэгтгэл тайлангуудаас өгсөн зөвлөмжүүдийг судалж, шийдвэр гаргахад санал боловсруулах, гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавина.

- Энэ 2 баримт бичгийн хүрээнд гаргасан зөвлөмжүүдийг 2017 оны ажлын төлөвлөгөө болон Хараат бус хянагч нэгтгэгчийн ажлын даалгаварт орсон эсэхийг нягталж, холбогдох засварыг оруулах санал гаргаж Ажлын хэсэгт танилцуулна.
- Өмнөх 2012, 2013, 2014 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлангуудаар өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг дахин нягталж, дүгнэлт хийх, шийдвэрийн саналыг Ажлын хэсэгт танилцуулна.

Ажлын хэсгийн 44 дүгээр хуралдаан 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Пума зочид буудалд болсон. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. Европын Сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилттэй орон нутгийн харилцааны туршилтын төслийн хүрээнд жишиг 5 суманд хэрэгжүүлэх стратегийг ажлын гишүүдээс гарсан саналтай нэгтгэн энэ стратегт нэгтгэх, нэмэж санал өгөх гишүүд 6 дугаар сарын 23-ны дотор саналаа Ажлын албанд ирүүлэх, ирсэн саналыг нэг долоо хоногийн нэгтгэн боловсруулж, стратегтээ оруулж, батлуулахаар тогтов. Ажлын хэсэг энэ асуудлаар дахин хуралдах эсхийг жич тогтохоор болсон.
2. Монголын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн эхлэлийн тайланд ажлын гишүүдээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, эхлэлийн тайланд оруулж, зарчимын хувьд батлав. Эхлэлийн тайлантай холбогдсон саналаа эцсийн байдлаар ажлын 3 хоногт багтаан ирүүлэхээр тогтов.
3. Засгийн газрын 222- р тогтоолд оруулах нэмэлт өөрчлөлтийг ажлын гишүүдээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, тогтоолын төслийг эцэслэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт танилцуулахыг Ажлын албанд даалгав. Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны ажлын төлөвлөгөөний "Аймгийн дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх" 11-р Зорилтын дагуу дэд хэсэг байгуулж, дэд зөвлөлийн хамрах хүрээ, санхүүжилтийн судалгааг хийхийг Ажлын албанд даалгав. Энэ дэд хэсэгт орох хүний нэрийг оролцогч талууд **6 дугаар сарын 30-ны** дотор Ажлын албанд ирүүлэхээр тогтов. 2017 оны Ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр гаргаж, гишүүдэд хүргүүлэхээр тогтов.
4. Материаллаг босгыг шинэчлэн боловсруулах дэд Ажлын хэсгийг ажиллуулахаар болов. Бүрэлдэхүүнд оролцогч тал бүрээс орох 2 хүний нэрийг **6 дугаар сарын 30-ны** дотор Ажлын албанд ирүүлэхээр тогтов

Ажлын хэсгийн 45 дугаар хуралдаан 2017 оны 11 дугаар сарын 15-ны өдөр Пума зочид буудалд болов. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. Монголын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанд сайтар бэлтгэж, танилцуулж, батлуулахыг КиПиЭмЖи компани, Ажлын албанд даалгав. Мөн Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн шүүмжийн дагуу Үндэсний зөвлөлийн хурлаас өмнө тодруулга, тайлбар өгөх үүргийг холбогдох байгууллагуудад ЗГХЭГ-ын даргын албан тоотыг хүргүүлж, гүйцэтгэлийг хангуулах, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас КиПиЭмЖи-д хариу өгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг оруулаад эзэмшигч бүх аж ахуйн нэгжүүд хамрагдаж байгаа эсхийг эргэн нягтлах, Компаниудад торгууль төл гэсэн шаардлага тавихаас ойлгуулах, сургах ажлыг цааш цаашдаа анхаарч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт санал болгох, КиПиЭмЖи компанийн зүгээс дутуу хийгээд байгаа асуудлуудыг гүйцээх, монгол тайлангийн редакцийг сайжруулах, Ажлын даалгаварт ороогүй ч тайлангийн хураангуй хувилбар гаргах талаар хамтран ажиллахаар тохиролцов. Мөн Иргэний нийгмийн ТАН эвслээс 2016 оны нэгтгэл тайланд өгөх нэмэлт саналаа бичгээр бусад төлөөллүүдэд Ажлын албаар дамжуулан ирүүлж, зөвшилцсөний үндсэн дээр КиПиЭмЖи-д хүргүүлэх, КиПиЭмЖи-д гэрээ ёсоор холбогдох графикт төлбөр 60 хувийг төлөхийг Ажлын албанд зөвшөөрөв.
2. Ашиг хүртэгч жинхэнэ эздийг ил тод болгохтой холбоотой хууль эрхзүйн ойлголтын тодорхойлолтуудын баталсан гэж үзээд Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд

- Үйлдвэрийн яамдад хүргүүлэх болон Замын Зураг- ийн биелэлтийн, шинэчлэн зөвшөөрч, Үндэсний зөвлөлийн зөвлөлд танилцуулж, батлуулахыг Ажлын албанд даалгав.
3. Ажлын хэсгийн ажиллах журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлав. Холбогдох нэмэлт өөрчлөлт бүхий журмыг цахим хуудас дээрээ байршуулахыг Ажлын албанд даалгав. Мөн оролцогч талууд Ажлын Хэсэг, Үндэсний зөвлөлд ажиллах, томилох журмаа шинэчилэн баталж, Ажлын албанд 12 дугаар сарын 1-ний дотор ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын газрын дарга Д. Ганбаатар, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Төлсөн авснаа нийтэл эвслийн зохицуулагч, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд нарт даалгав.
 4. 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн явцыг сонсоод 2017 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үлдсэн хугацаанд хангаж ажиллахыг бүх тал болон Ажлын албанд даалгав. Ерөнхий сайдын ажлын албаны зүгээс 2018 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлсэн байдлыг олон нийтэд илүү хүртээмжтэй хэлбэрээр хүргэх чиглэлээр Ажлын төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байгаа тул 2018 оны төлөвлөгөөг боловсруулах ажилд идэвхтэй оролцохыг бүх оролцогч талд уриалав. 2017 оны Ажлын төлөвлөгөөний биелэлт болон 2018 оны төлөвлөгөөний төсөлд ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналуудыг тусган Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд даалгав. 2017 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд оролцогч тал бүр өөрийн зүгээс хийсэн ажлуудын талаар танилцуулга болон үнэлгээ бэлтгэж, Ажлын албанд 12 дугаар сарын 10-ны дотор өгөхийг оролцогч талуудын ахлагч болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын газрын дарга Д. Ганбаатар, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Төлсөн авснаа нийтэл эвслийн зохицуулагч, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд нарт даалгав.
ОУНБТНГ-т жил бүр илгээдэг 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайланг хамтад нь боловсруулж ҮЗ ийн хурлаар оруулж хэлэлцэн батлах нь зүйтэй.
 5. ОУИТБС-ын орон нутгийн туршилтын төслийн явцтай танилцав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15- ны 308 дугаар тогтоол

ОУИТБС-ын олон улсын байгууллагын гишүүний татварыг 10,000 ам. доллароор тогтоож, хэрэгжүүлэгч орнууд 2017 оноос эхлээд төлөх болсон тул Засгийн газраас тогтоол гаргаж шийдвэрлэсэн байна.

2017 оны 9 дүгээр сарын 24-29-ны өдрүүдэд Мьянмар Улсын ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд Монгол Улс айлчилж туршлага судлав.

Мьянмар Улсын ОУИТБС-ын ажлын хэсгийн 10 гишүүн Монгол Улсад айлчиж, ОУИТБС-ын хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцаж, Монголын Ажлын хэсгийн гишүүдтэй хамтарсан семинар, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, Төв аймгийн Заамар суманд очиж, сумын дэд зөвлөлийн ажил болон Монполимет компанийн нөхөн сэргээлт зэрэгтэй танилцсан байна. Энэ аялалыг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн санхүүжүүлж, хамтран ажилласан байна.

2017 оны 10 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Филиппины нийслэл Манила хотноо Зүүн, Өмнөд Ази, Номхон далайн бүсийн сургалт семинарт оролцов.

Энэ семинарын үеэр зохиогдсон ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны ээлжит хуралдаанд Ерөнхий сайдын ажлын албаны референт Г.Анхбаяр Монгол Улсын ОУИТБС-ын цахим тайлагналын систем, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг Монголын ОУИТБС-ын хүрээнд орон нутгийн орлогыг ил тод болгож байгаа тухай, мөн семинарын оролцогч нарт ОУЗСТ-ийн ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон ОУИТБС-ын баталгаажуулалтын дүнгийн талаар танилцуулга хийсэн байна.

Найм. Тайланг боловсруулсан:

Тайланг боловсруулсан: 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр,

Баталсан огноо: 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Ес. Хавсралтууд

1. Монголын ОУИТБС-ын 2017 оны төлөвлөгөөний биелэлт
2. Монголын ОУИТБС-ын 2018 оны төлөвлөгөө
3. Монголын ОУИТБС-ын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох 2020 он замын зураг төлөвлөгөөний биелэлт, шинэчлэгдсэн хувилбар
4. Оролцогч талуудаас хийсэн ажлын товч танилцуулга.

Хавсралт

Дөрөв: Оролцогч талуудаас хийсэн ажил

1. Засгийн газар

- a. Монгол Улсын Засгийн газраас дээр дурдсан 263, 308 дугаар тогтоолуудыг холбогдох шийдвэрүүдийн хамт гаргаж, ОУИТБС-ыг хэрэгжилтийг дэмжих бүх талын арга хэмжээ авч ирсэн байна.
- b. Мөн Монгол Улсын Уул Уурхай, Хүнд үйлдвэрийн яамнаас “Уул уурхайн тухай” хуулийн төслийг боловсруулж, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 9.5-д “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзнэ” гэж заасны дагуу хуулийн төслийг дараах байгууллага, аж ахуйн нэгжүүдэд танилцуулж санал авч саналыг хуулийн төсөлд тусгах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:

“Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн удирдлага, инженер техникийн ажилтнууд, Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын алба, Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт, Ашигт малтмал ил аргаар олборлогчдын технологийн инженерүүдийн холбоо, Уул уурхайн хүрээлэн, Маркшейдерийн холбоо, Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын экспортлогчдын холбоо, Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо, Канадын СЕСМИМ төсөл зэрэг уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагын төлөөлөл, ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Уул уурхайн салбарын багш, эрдэмтэн, доктор, профессорууд, Монгол Нүүрс ассоциаци, түүний гишүүн байгууллагууд болох “Энержи Ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Саус гоби сэндс” ХХК, “Шарынгол” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг нүүрсний олборлолт хийдэг компаниуд, Нээлттэй нийгэм форумаас зохион байгуулсан иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан 2 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг авсан байна.

Мөн Канадын ЭСЯ-аас зохион байгуулсан Канадын ЭСЯ, АНУ-ын ЭСЯ, Австралийн ЭСЯ, Английн ЭСЯ, Олон улсын валютын сан, БНСУ-ын Койка, Миреко, Канадын Мерит төсөл, Сесмим төсөл, Швейцарийн холбооны улсын Тогтвортой бичил уурхай төсөл зэрэг донор орнуудын ЭСЯ, байгууллагуудад Уул уурхайн тухай хуулийн төслийг танилцуулж, саналыг авсан байна.

Яамны веб сайт дээр Уул уурхайн тухай хуулийн төсөл, Уул уурхайн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг тавьж, олон нийтээс санал авсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого, Уурхайн хаалтын журам” сэдэвт уулзалт семинарт Уул уурхайн тухай хуулийн төслийн талаар танилцуулга хийсэн.

Геологийн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөлд Уул уурхайн тухай хуулийн төслийн талаар танилцуулыг тус тус хийсэн байна.